



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/2/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхтогтох Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	6
2.8.3 Бараа материал	7
2.8.4 Үндсэн хөрөнгө	7
2.8.5 Өр төлбөр.....	8
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА Э.ГАНБАЯР ТАНАА
<u>2020.03.25</u> № <u>1-6/363</u> танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Эрдэнэ сумын Засаг дарга Э.Ганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 18-аас 2020 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 03/91 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 1,099.2 сая төгрөгийн 1 хувь буюу 10.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 26.0 сая төгрөгөөр тогтоосон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлттэй байгууллага байхгүй байна.

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 67.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 62.6 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 0.6 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 2.5 сая төгрөгөөр авлагыг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 0.8 сая төгрөгөөр санхүүжилтийн орлого дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 1.7 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн.

Төвлөрүүлэн захирагчийн алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 62.6 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Засаг даргын Тамгын газар Биеийн тамирын задгай талбайг эх үүсвэрээс хамааруулж, үндсэн хөрөнгөд 60.1 сая төгрөгөөр хувааж бүртгэсэн байсныг аудитын явцад залруулга хийсэн.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг дутуу тооцсоныг санхүүгийн тайланд залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 60.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 134.8 сая төгрөг болж 74.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	60.1	134.8	74.7	224
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	60.1	134.8	74.7	224

Эх сурвалж: Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 134.8 сая төгрөг нь Засаг даргын Тамгын газрын Ахмадын сан 0.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 22.3 сая төгрөг, Сум хөгжүүлэх сан 72.2 сая төгрөг, Нөхөн сэргээлтийн сан 31.6 сая төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8.4 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 198.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 121.8 сая төгрөг болж, 77.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	0.0	3.0	3.0
Бусад авлага	44.3	0.3	-44.0
Зээлийн авлага	154.5	118.5	-36.0
Дүн	198.8	121.8	-77.0

Эх сурвалж: Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 119.1 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуулийн 0.2 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Ерөнхий боловсролын сургууль – Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоо хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

2.8.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 277.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 315.7 сая төгрөг болж, 37.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	70.8	88.5	17.7
Эм боох материал	0.6	14.5	13.9
Сэлбэг хэрэгсэл	3.4	3.4	0
Бичиг хэргийн материал	10.2	10.3	0.1
Аж ахуйн материал	19.3	20.9	1.6
Түлш шатах тослох материал	1.3	3.2	1.9
Хүнсний материал	6.0	6.3	0.3
Барилгын засварын материал	7.8	2.7	-5.1
Бусад хангамжийн материал	156.1	163.3	7.2
Мал амьтад	2.3	2.6	0.3
Дүн	277.8	315.7	37.9

Эх сурвалж: Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2.8 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 84.4 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 102.2 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 47.3 сая төгрөг, Соёлын төв 11.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 67.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Хүүхдийн цэцэрлэг – 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээр тайлагнаж байх зөвлөмж өгсөн боловч аж ахуйн материалын тайланг нийт дүнгээр тайлагнасан байна.

Эрүүл мэндийн төв – Бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгээгүй байна.

2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,680.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,875.1 сая төгрөг болж, 194.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,483.2	1,505.9	22.7
Хуримтлагдсан элэгдэл	-11.5	-70.5	-59.0
Авто тээврийн хэрэгсэл	260.1	293.1	33.0
Хуримтлагдсан элэгдэл	-178.5	-218.2	-39.7
Машин тоног төхөөрөмж	423.2	446.3	23.1
Хуримтлагдсан элэгдэл	-283.6	-324.3	-40.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	158.5	189.3	30.8
Хуримтлагдсан элэгдэл	-69.3	-85.5	-16.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.2	0.2	0.0
Бусад үндсэн хөрөнгө	1,011.2	1,178.8	167.6
Хуримтлагдсан элэгдэл	-266.2	-282.9	-16.7
Дуусаагүй барилга байгууламж	0.0	88.5	88.5
Ном	16.0	16.4	0.4
Програм хангамж	115.5	116.7	
Хуримтлагдсан элэгдэл	-1.6	-1.9	1.2
Бусад биет бус хөрөнгө	23.6	23.6	-0.3
Хуримтлагдсан элэгдэл	-0.4	-0.4	0.0
			0.0
Дүн	2,680.4	2,875.1	194.7

Эх сурвалж: Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 21.6 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 257.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Балансаас балансад шилжүүлсэн, акталж хасагдсан хөрөнгө байхгүй.

Аудитын илрүүлэлт:

Ерөнхий боловсролын сургууль – Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.

2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8.3 сая төгрөг болж, 5.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг				
Байгууллагад төлөх өглөг	2.7	8.3	5.6	307
Хувь хүмүүст төлөх өглөг				
307				
Дүн	2.7	8.3	5.6	307

Эх сурвалж: Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд нэмэлт санхүүжилтийн 8.3 сая төгрөгийн өглөг байна.

2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,215.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,489.5 сая төгрөг болж, 274.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,686.4	1,779.1	92.7	105
Өмч /төрийн/ /ТӨҮГ/ Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	92.7	0.0	-92.7	100
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	1,326.8	1,445.9	119.1	108
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109.5	264.5	155.0	241
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	3,215.4	3,489.5	274.1	108

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансанд өөрчлөлт ороогүй. Бодлогын өөрчлөлт алдааны залруулга байхгүй.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай А/06 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 104.8 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 143 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	2.7	6.0	-3.3	222
Хадгаламжийн хүүгийн орлого	17.9	20.3	-2.4	113
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	15.9	40.1	-24.2	252
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	0.2	0.1	0.1	50
Бууны албан татвар	2.1	2.0	0.1	95
Улсын тэмдэгтийн хураамж	1.8	15.6	-13.8	867
Ан агнах зөвшөөрлийн хураамж	53.9	59.7	-5.8	111
Хог хаягдлын хураамж	9.5	5.7	3.8	60
Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.2	0.2	0.0	100
Хүү торгуулийн орлого	0.6	0.7	-0.1	117
Нийт дүн	104.8	150.4	-44.6	143

Үйл ажиллагааны орлого 3.3 сая төгрөгөөр давсан нь хувиараа бизнес эрхлэгч иргэн 10 айлын орон сууцыг ашиглалтад оруулсантай холбоотойгоор, улсын тэмдэгтийн хураамж 13.8 сая төгрөгөөр давсан нь 2018 онд тухайн аж ахуйн нэгж байгууллага нь улсын тэмдэгтийн хураамжаа харьяаллын Татварын хэлтэст тушаадаг байсан, 2019 онд ан агнах зөвшөөрөл авсан орон нутгийн татварт төвлөрүүлснээс шалтгаалсан, хадгаламжийн хүүгийн орлого 2.4 сая төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламжийн үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 24.2 сая төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны мөнгөний урамшууллын 2018, 2019 оны татвар орсноос, Ан агнах зөвшөөрлийн хураамж 5.8 сая төгрөгөөр давсан нь тухайн үеийн валютын зөрүүгээр нэмэгдсэн, Хүү торгуулийн орлого 0.1 сая төгрөгөөр давсан нь Хилийн 0129 дүгээр ангийн хилийн заагт малчдын хариулгагүй мал тулж торгуулснаас, Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 0.1 сая төгрөгөөр тасарсан нь үл хөдлөх эд хөрөнгийн борлуулалт явагдаагүй, Хог хаягдлын хураамж 3.8 сая төгрөгөөр тасарсан нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор хот суурин газрын айл өрхөөс авахаар заагдсан боловч сумын бүх өрхийн тоогоор ногдуулалт хийсэн, Бууны албан татвар 0.1 сая төгрөгөөр тасарсан нь 3 иргэн буугаа ашиглахаа больж цагдаад хураалгаснаас тус тус шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 2,040.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,826.6 сая төгрөгийг урсгал зардалд, 213.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 761.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 955.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 213.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 85.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 2,040.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 760.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 20.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 930.4 сая төгрөг, 169.0 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 52.0 сая төгрөг, нийт 1,931.8 сая төгрөг санхүүжүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого батлагдсан 1.0 сая төгрөгөөс төсвөөс 0.5 сая төгрөгөөр биелж 0.5 сая төгрөгөөр тасарсан байна. Тасарсан шалтгаан нь төсөвт байгууллагын дансанд бүртгэлтэй төрийн албан хаагчийн 4 орон сууцнаас 1 байр хувьчлагдан, 1 байр нь ашиглах боломжгүй их засвар орох шаардлагатай улмаас айл түрээслэн суудаггүйтэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 213.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 147.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,862.9 сая төгрөг буюу 91 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн дээд шатны төсвийн захирагчаас 103.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.9 сая төгрөг, нийт 129.0 төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 120.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, бусад гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлсэн 0.2 сая төгрөгийн нохойн хураамжийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан журамд үндэслэн иргэдээс хураадаг байна. Гэвч энэ төрлийн орлого нь тус дансны эх үүсвэрийн төрөлд заагдаагүй, орлогын эрх зүйн үндэслэл, журмыг авч үзэхэд уг орлого нь байгаль хамгаалах санд төвлөрүүлэх заалттай. Мөн тус дансанд төвлөрсөн 0.5 сая төгрөгийн байгалийн үзэсгэлэнт газраар зорчих иргэдээс хураадаг орлого нь дансны орлогын эх үүсвэрт заагдаагүй, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 5.1-д заасны дагуу тусгай санд төвлөрүүлэх заалттай байна.

3.1.2 Эрсдэл: Хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид нөхөн сэргээлтийн санд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-д зааснаас бусад төрлийн орлогыг төвлөрүүлэхгүй байх, тус журамд зааснаас өөр төрлийн зориулалт бус зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	537,784.7	622,728.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60,054.0	134,817.1
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	60,054.0	134,817.1
31210	Төгрөг	60,054.0	134,817.1
31211	Төрийн сангийн харилцах	60,054.0	134,817.1
33	АВЛАГА	198,811.5	121,821.7
33400	Зээлийн хүүгийн авлага	0.0	3,033.0
33500	Бусад авлага	44,351.3	260.0
33510	Байгууллагаас авах авлага	44,351.3	260.0
33600	Зээлийн авлага	154,460.2	118,528.7
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	154,460.2	118,528.7
33612	Хувь хүмүүст олгосон зээл	154,460.2	118,528.7
34	УРЬДЧИЛГАА	-	49,265.5
34600	Урьдчилж гарсан зардал	-	49,265.5
35	БАРАА МАТЕРИАЛ	277,780.2	315,685.6
35100	Түүхий эд материал	71,340.5	102,996.5
35110	Тусгай зориулалттай материал	70,790.5	88,516.4
35130	Эм боох материал	550.0	14,480.0
35400	Хангамжийн материал	204,119.7	210,039.1
35410	Бичиг хэргийн материал	10,202.5	10,347.3
35420	Аж ахуйн материал	19,345.6	20,921.7
35430	Сэлбэг хэрэгсэл	3,360.0	3,360.0
35440	Түлш, шатах тослох материал	1,326.7	3,161.4
35450	Барилгын засварын материал	7,807.0	2,570.0
35460	Хүнсний материал	6,029.5	6,349.8
35470	Бусад хангамжийн материал	156,048.3	163,329.0
35600	Мал амьтад	2,320.0	2,650.0
36	НӨӨЦИЙН БАРАА	1,139.0	1,139.0
36300	Тэжээлийн нөөц	1,139.0	1,139.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,680,410.9	2,875,049.1
